

АВЛИГЫН ЭСРЭГ ТЭМЦЭХЭД ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ҮҮРЭГ

Г.Мэндхүү*, Н.Ариунзаяа**

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн институт, авлигын эсрэг ажиллагаа

Үндэсний эдийн засгийн хөгжилд саад тотгор болж, улс орны нэр хүндэд сөргөөр нөлөөлж, иргэдийн төрдөө итгэх итгэлийг бууруулдгийн хувьд авлига нь Монгол Улсын өмнө тулгарч байгаа олон сорилтуудын нэг болоод байна. Иймээс авлигын тухай асуудал нь нийгмийн анхаарлын төвд орж, энэ чиглэлд тодорхой ажил хийж асуудал шийдвэрлэх зайлшгүй эрэлт байгааг төрийн бодлого тодорхойлогчид ч ойлгосон. Манай Монгол Улсад авлигатай тэмцэх хүрээнд нэлээн далайцтай томоохон алхмуудыг хийснээс хамгийн чухал заримыг нь дурдъя.

– Монгол Улсын Их Хурал анх 1996 оны 4 дүгээр сарын 5-нд Авлигын эсрэг хууль баталсан. Нийгмийн сэтгэлгээний өөрчлөлт, цаг үе, улс төр, эдийн засгийн бодит нөхцөл байдалтай уялдуулан авлигын эсрэг хуулийг шинэчлэх шаардлага зүй ёсоор гарсан бөгөөд 2006 оны 7 дугаар сарын 6-нд Монгол Улсын Их

Хурал авлигын эсрэг хуулийг шинээр баталсан. Хууль 2006 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Авлигын эсрэг хуульд цаг үеийн шаардлагад нийцүүлэн нийт 20 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулжээ. Хамгийн анхны нэмэлт өөрчлөлт 2008 оны 5 дугаар сарын 29-нд байсан бол хамгийн сүүлийн нэмэлт өөрчлөлт 2022 оны 12 дугаар сарын 16-нд хийгджээ.

– 2002 онд Монгол Улс Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг баталж, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих орон тооны бус Үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулсан.

– Авлигын эсрэг хуультай уялдуулан Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Ингэснээр авлигын түвшинг бууруулахад эрх зүйн орчин цогц байдлаар бүрэлдсэн гэж зоригтойгоор хэлж болох юм.

– Монгол Улсын Их Хурал 2005 оны 10 дугаар сарын 27-нд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг соёрхон батлах шийдвэр гаргаж байв (Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон

батлах тухай , 2005). Авлигын эсрэг олон улсын конвенцыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2003 оны 10 дугаар сарын 31-нд баталж байв. Энэ конвенцод нэгдэж байгаа улс орнууд гарын үсэг зурж баталгаажуулах ёслол 2003 оны 12 дугаар сарын 9-нд Мексик Улсын Мерида хотод болж түүхтэй.

- Авлигын эсрэг хуулийн дагуу Монгол Улсад анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага-Авлигатай тэмцэх газар байгуулсан. Тус байгууллага 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс үйл ажиллагаагаа тогтмол явуулж эхэлсэн.

Авлигатай тэмцэх тусгай байгууллага үйл ажиллагаа явуулдаг болсноор авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэхээс эхлээд олон нийтэд авлигын сөрөг үр дагаврыг ойлгуулахын тулд соён гэгээрүүлэх ажлыг тогтмол хийж эхэлсэн. Хэрвээ нэгэнт авлига өгсөн, авсан үйлдэл баримт бүртгэгдсэн бол үүнийг шалгаж, үнэн мөнийг нь тогтоох, улмаар хуулийн хүрээнд буруутай этгээдэд хариуцлага тооцох механизмыг ч Авлигатай тэмцэх газар бий болгосон.

Авлигатай тэмцэх чиглэлээр дэлхийн аль ч улсын төр засгийн байгууллага хүчин чармайлт гаргаж байгаа ч авлигын шинжтэй үйлдэл нийгэмд байгаа гэдгийг олон нийт ахуйн хүрээнд өөр хоорондоо ярилцах нь түгээмэл байдаг. Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоогүйгээр төр засаг дангаараа авлигатай тэмцэх үйлсэд бүрэн амжилт гаргах боломжгүй гэдэг үзэл санаа аксиом болоод байна (Билоус Е.Н., Дотоод хэргийн байгууллага ба түүний шуурхай алба хэлтсүүд иргэний нийгмийн байгууллагатай харилцах асуудалд, 2011). Үүний зэрэгцээ авлигын эсрэг

хууль эрх зүйн баримт бичгүүд нь иргэний нийгмийн байгууллагуудыг дээрх асуудлыг шийдвэрлэхэд оролцох өргөн боломжийг нээж өгч байна.

Иргэний нийгмийн төлөөллийн байр суурь нэн чухал байна. Ялангуяа “дөрөв дэхь засаглал” гэж ач холбогдол нь өндрөөр үнэлэгддэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (ОНМХ) чухал оролцоотой. Учир нь сэтгүүлчид нийгмийн амьдралын янз бүрийн салбарт өрнөж байгаа үйл явдлын гэрч болж, олон түмний өмнө тулгамдсан асуудлыг хөндөж уран бүтээл туурвидаг. Иймд хэвлэл мэдээллийн салбарынхан авлигатай тэмцэх үйлсэд хувь нэмэр оруулж, олон нийтийн сайн сайхны төлөө, нийгэмд шударга байдлыг тогтооход гол хянагч болох юм. Сэтгүүлчдийн хүн амын ухамсарт нөлөө үзүүлэх чадвар боломж өндөр, нийгмийн бүлэг давхарга бүрийн гишүүн биеэ авч явахдаа баримтлах зарчим, дэг журмыг оюун санаанд төлөвшүүлдэг (И.Ю., 2014).

Олон түмнийг нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодит мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэрэг мэдээллийн сувгийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж нэрлэдэг. ОНМХ нь үнэн бодитой, тогтмол, шуурхай, хүртээмжтэй, багтаамж сайтай, идэвхтэй, ашигтай, чиглэсэн зорилготой байх зэрэг шинжээрээ бусад бүх төрлийн мэдээллээс ялгардаг (Зулькафил, 2018). Авлигын сэдвийг хөндсөн сэтгүүлчийн бэлтгэсэн мэдээ, сурвалжилга, ярилцлага, өгүүлэлд гол төлөв асуудлыг илчилж дэлгэж гаргасан шинж чанар анзаарагддаг. Сэтгүүлчдэд зориулсан авли-

гын асуудлаар хэрхэн мэдээлэл бэлтгэх вэ? гэдэг боловсруулсан аргачлал, хэрэгжүүлж болох зөвлөмж нэгдсэн байдлаар хэн ч хийгээгүй байна. Иймд сэтгүүлчид ба хууль сахиулах байгууллагын хооронд ойлголтын зөрүү үүсдэг, сэтгүүлчийн олж авсан баримт нь дутуу дулимаг, баримтаа хоёр ба түүнээс дээш эх сурвалжаар баталгаажуулаагүй, олж авсан мэдээллээ хангалттай түвшинд бүрэн боловсруулаагүй байх тохиолдол түгээмэл байна. Үүний улмаас сэтгүүлч авлигын асуудалтай холбоотой сэдвээр бүтээл бичиж олон түмэнд мэдээлэхдээ бодитой үр дүнд хүрч, нийгэмд өөрчлөлт авч ирье гэсэн том зорилгодоо хүрч чадахгүй байх, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байдаг нөөц боломж үр дүнгүй тарамдах нөхцөл үүсдэг.

Бидний үзэж буйгаар олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд авлигын сэдвийг хөндөж бүтээл туурвихдаа доорх зүйлүүдийг анхаарч харгалзан үзэх хэрэгтэй байна. Үүнд:

- олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд хэн нэгэн хүн авлига авсан, өгсөн гэдгийг сенсаац болгож мэдээлэхээс илүү шалтгааныг нь үндсээр нь арилгахад чиглэсэн сэтгүүл зүйн бүтээл түгээхэд ач холбогдол өгөх;
- авлигын шинжтэй үйлдлийн хэлбэр, ямар салбарт илэрч болзошгүй вэ гэдгийг хөндвөл мэдээлэл хүлээн авагчдын тоогоо нэмэгдүүлж, нийгмийн дэмжлэг авч улмаар зар сурталчилгаанаас олох орлогоо нэмэгдүүлэх боломжтой. Ийм мэдээллийн ачаар нийгэм даяараа авлигын далд механизмыг мэддэг болсноор цаашид “нийгмийн хорт хавдар” гэж нэрлэж болох авлига гаарах боломж олгохгүй.
- иргэн, төрийн албан хаагч, бизнесийн төлөөлөлд авлигын асуудлыг хэлэл-

цэх боломж олгосон индэр нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болж, нийгмийн бүх субъект үйл ажиллагаандаа авлига үүсэх нөхцлийг хаах арга тодорхой болгоход нь туслах;

- улс орны дотоодод ба хилийн чанадад авлигатай тэмцэж үр дүнд хүрсэн сайн туршлагын танилцуулж мэдээлэх, авлигын шинжтэй үйлдэл гарахаас сэргийлж байгаа алхам, арга зүйг сурталчлах;

- хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх хүрээнд авлигын тухай танин мэдэхүй, ёс суртахууны хэм хэмжээг сурталчилсан, авлигын асуудлаарх хууль эрх зүйн мэдлэгийг нь тэлэх агуулгатай бүтээлийг тодорхой давтамжтайгаар олон түмэнд дамжуулна гэдгээ нийтлэл нэвтрүүлгийн бодлогодоо тусгах;

- авлигатай тэмцэх үйлсэд зориулах үйл ажиллагааны санхүүжилтийг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээллийн бодлогоороо дамжуулан нөлөөлж чадна гэдгээ ухамсарлах зэрэг болно.

Манай улсад 1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд төрийн байгууллага дэргэдээ олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулж, үйл ажиллагааг нь санхүүжүүлэх боломжгүй гэсэн үзэл санааг оруулсан. Монгол Улсын хувьд МОНЦАМЭ агентлаг, МҮОНРТ-ээс бусад тогтмол хэвлэл, радио, телевиз, цахим мэдээллийн сайтууд бүгд өмчийн хэлбэрийн хувьд хувийнх. Ийм нөхцөлд дээр дурдсан зүйлүүдийг хувийн өмчийн арилжааны зарчмаар ажиллаж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагуудад хандан шууд хэрэгжүүлэхийг санал болгох нь янз бүрийн хариу урвал гарахад хүргэнэ. Дийлэнх

тохиолдолд авлигыг хумихын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд анхаарлаа хандуулна гэдэгт санал нэгдэх нь хүн төрөлхтөний нийтлэг үнэт зүйлсэд тулгуурлаж үйл ажиллагааны зарчмаа бүрдүүлэхийг зааж номлодог ардчилсан чөлөөт сэтгүүл зүйн үзэл санаатай яв цав нийцэж байна.

Авлигын асуудлаар иж бүрэн цогц мэдээллийг түгээхэд хамгийн тохиромжтой нь өмчийн хэлбэрийн үүднээс авч үзвэл, олон нийтийн радио, олон нийтийн телевиз юм. Манай улс 2005 онд олон нийтийн радио телевизийн тухай хууль баталсан. Энэ хуулийн гол үзэл санаа нь олон нийтийн радио, олон нийтийн телевиз нь хараат бус байж, нийгмийн сайн сайхны төлөө, нийгмийн бүх гишүүдийн байр суурь, дуу хоолойг хүргэхэд чиглэнэ гэсэн байдаг. Дэлхийн аль ч улс оронд авлигатай тэмцэх байгууллага нь хэвлэл мэдээллийн хэрэгслийнхэнд хандаж авлигын гэмт хэргийг илрүүлсэн тухай мэдээлэл өгч, тоо баримт, харьцуулсан мониторинг танилцуулдаг. Монгол Улсын АТГ авлигын хэргийг илрүүлж, зохих үнэлэлт дүгнэлт гаргасан гэдгээ хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд зориулан тодорхой давтамжтайгаар, заримдаа шуурхай хэвлэлийн бага хурал зохион байгуулах зэргээр сэтгүүлчдэд хандан мэдээлэх нь уламжлал болсон гэдэг нь манай судалгааны ажлын явцад анзаарагдсан. Нэгдсэн байдлаар хэвлэлийн бага хурал зохион байгуулж авлигын тухай албан ёсны мэдээлэл түгээснээр нийгэм олон нийт зөв мэдээлэлтэй болох, хууль сахиулах байгууллага, төр засагтаа итгэх итгэлийг нэмэгдүүлэх эерэг талтай гэдгийг цохон тэмдэглэе. Энд өгүүлсэн

бүхнийг нэгтгэж үзвэл авлигын эсрэг үр дүнтэй тэмцэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн оролцоо туйлын чухал гэдэг илэрхий байна. Ялангуяа, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төрийн ба төрийн бус байгууллагууд, бизнесийн төлөөлөл зэргээс хараат бус бие даасан байх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан авлигын шинжтэй үйлдлийн тухай мэдээлэлд энэ асуудлыг хариуцсан тусгай чиг үүрэгтэй хууль сахиулах байгууллага цаг алдахгүй анхаарлаа хандуулах нь маш сайн хамтын ажиллагаа болж хувирна.

Гэвч манай судалгааны багийнхны үзэж буйгаар, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн бүх үйл ажиллагаа хуулийн хүрээнд байх ёстой. Иймд хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж байгаа зохиогчийн, зохион байгуулалтын, редакторын зэрэг ажил үүрэг гүйцэтгэж байгаа нийт сэтгүүлчид авлигын эсрэг тэмцэх эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаа Монгол Улсын хууль эрх зүйн баримт бичгүүдийг судлах, дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч сахин мөрдөж байгаа Авлигын эсрэг олон улсын конвенцийн тухай бүрэн дүүрэн ойлголттой болох нь хамгийн энгийн шаардлага болж байна. Үүнийг энгийн үгээр илэрхийлвэл Монгол Улсын хувьд АТГ хэрхэн ажилладаг, ямар чиг үүрэгтэй албан байгууллага вэ?, хуулиар олгогдсон ямар эрх, үүрэг байдаг вэ?, ямар үйлдлийг авлига гэж хууль зүйн шинжлэх ухаанд үзэж байна вэ гэдгийг ялгаж салгаж чаддаг байх хэрэгтэй гэсэн үг юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон батлах тухай хууль. 2005.10.27

2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай УИХ-ын тогтоол. 2016.11.03
3. Авлигын эсрэг Монгол Улсын хууль. 2006.07.06
4. Авлигатай тэмцэх газрын албан ёсны сайт. <https://iaac.mn/>
5. Билоус Е.Н., Васильев Н.Н., Харченко С.В. Дотоод хэргийн байгууллага ба түүний шуурхай алба хэлтсүүд иргэний нийгмийн байгууллагатай харилцах асуудалд. // ОХУ-ын Дотоод хэргийн яамны Академийн бүтээлүүд. Москва. 2011., № 2. х.48-53 (К вопросу об организации взаимодействия органов внутренних дел и их оперативных подразделений с институтами гражданского общества в сфере противодействия коррупции // Труды Академии управления МВД России.)
6. Зулькафилъ М. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 2018
7. Никодимов И.Ю. Төр мэдээлэл харилцааны үүргээ хэрэгжүүлэхэд ОНМХ-ийн байр суурь ба оролцоо. Москва. 2014. № 8. - х. 148. (Место и роль средств массовой информации в механизме реализации информационно-коммуникативной функции государства // Инновации и инвестиции.)
8. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2006 он, №35

Summary

The manifestations of corruption damage the image of each country, so the issue of combatting terrorism is of state significance. The authors reveal the role of mass media as civil society institutions, its specificity in dealing with the problem. The author developed the conditions of increasing the effectiveness of mass media in combatting corruption.

Keywords: mass media, civil society institutions, combat corruption.